


БАТЛАВ
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Б.МӨНГӨНХУЯГ



НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ ЦАХИЛГААН
ШАТ ШИНЭЧЛЭХ АЖИЛ (15, 34 ДҮГЭЭР ХОРОО)-ЫН
ДААЛГАВАР

2024 оны 08 дугаар сарын 03

Дугаар 24/47

Улаанбаатар хот

1	Ажил гүйцэтгэх үндэслэл	- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 122 дугаар тогтоол - Нийслэлийн Засаг даргын эрх шилжүүлэх тухай 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1528 дугаар захирамж
2	Барилга байгууламжийн байршил	Шинэчлэх: - 15 дугаар хороо 23в дүгээр байрны 4 дүгээр орц - 15 дугаар хороо 26 дугаар байр /ачааны лифт/ - 15 дугаар хороо 22 дугаар байрны 1-р орц - 15 дугаар хороо 23а байрны 4-р орц - 15 дугаар хороо 29 дүгээр байр /ачааны лифт/ - 34 дүгээр хороо 21 дүгээр байр 2 дугаар орц - 34 дүгээр хороо 5б байр 2 дугаар орц Засварлах: - 34 дүгээр хороо 19 байр 1 дүгээр орц - 34 дүгээр хороо 21 байр 1 дүгээр орц
3	Зориулалт, хүчин чадал	- Цахилгаан шатны шинэчлэл - Цахилгаан шат засварлах
4	Зураг төсөл, бүрдэл	<u>Зураг төслийн иж бүрдэл:</u> - Цахилгаан шатны зураг - Ажлын төсөв - Тайлан
5	Ажил гүйцэтгэх үе шат, хугацаа	<u>1 үе шаттай</u> 1. Цахилгаан шатны засварын ажил гүйцэтгэж, хүлээлгэж өгөх. Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
6	Ажил гүйцэтгэх байгууллага	- Холбогдох тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллага.
7	Захиалагч байгууллага	- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

8	Техникийн шаардлага	<p>Улаанбаатар лифт НӨҮГ-аас боловсруулсан цахилгаан шатны техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэнэ.</p> <ol style="list-style-type: none"> 1. Лифтний засварын ажлыг гүйцэтгэхдээ ЗТБХБ сайдын 2008 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм"-ийг баримтална. 2. Лифтийг засварласны дараа ашиглалтад өгөхийн өмнө туршилтын ажлыг явуулахдаа захиалагч, ашиглалтын байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагуудын төлөөлөгчдийг байлцуулан гүйцэтгэнэ. 3. Лифтийг засварлах үе шатны ажил эхлэх дуусах бүрд захиалагч байгууллагыг байлцуулан шалгуулж шаардлага хангасан тухай акт үйлдсэний дараа цаашид хийх ажлыг үргэлжлүүлнэ. 4. Лифтний хонгилын хэсгийн барилгын үндсэн хийц эдлэлд өөрчлөлт оруулах, хучилтын хавтанд нэмэлт ачаалал өгөх, төхөөрөмж угсрах зорилгоор эвдэж гэмтээхийг хориглоно. 5. Зорчигчийн бүхээг болон жижүүрийн өрөө, машины өрөөний хооронд холбогдох телефон холбоотой байна.
9	Ажлын зохион байгуулалт	<ol style="list-style-type: none"> 1. Нийлүүлэгч дараах зүйлийг ажлын төлөвлөгөөнд тусгаж захиалагчид ирүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Гүйцэтгэх ажлын нарийвчилсан график; • Ажлын талбайг бэлтгэх; • Бараа нийлүүлэх график; • Ажлын талбай дээр барааг буулгах; • Хуучин сэлбэг хэрэгслийг буулгах; • Шинээр угсрах сэлбэг хэрэгслийг; 2. Нийлүүлэгч байгууллага нийлүүлэх барааны тодорхойлолт, техникийн шаардлага, түүнийг дагалдах болон ашиглалтын явцад хэрэглэгдэх хэмжих хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж зэргийг Монгол хэл дээр буулгаж захиалагчид өгнө. 3. Техникийн паспортад ажлын зураг, схем, гагнуур, суурь, далд ажил, газардуулгын зэрэг актуудыг бүрдүүлж, монгол хэл дээр буулгаж лифт ашиглагч байгууллагад хүлээлгэж өгнө. 4. Лифтийг нийлүүлэн угсрах байгууллага ажил эхлэх зөвшөөрлийг бараа нийлүүлэгдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор авсан байна. <ul style="list-style-type: none"> • Угсарсан шинэ лифтний туршилт тохируулгатай холбогдон гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. • Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан авах зөвшөөрлийн асуудлыг нийлүүлэгч буюу гүйцэтгэгч хариуцна. • Нийлүүлэгч үе шатны ажил дууссан нөхцөл бүрд мэргэжлийн байгууллагын төлөөлөгчийг байлцуулан угсралтын байдлыг шалгаж, техникийн магадлал хийж баталгаажуулан ажиглах зөвшөөрөл авна. • Ажлыг гүйцэтгэхэд дагаж мөрдөх норм, дүрмийн дагуу гүйцэтгэнэ. 5. Орон сууцны барилгын лифтийг шинээр засварласны дараа ашиглалтад оруулахын өмнө техникийн бүрэн туршилтыг захиалагч, гүйцэтгэгч байгууллага, хяналтын байгууллагатай хамтран хийж техникийн дүгнэлт гаргуулна. Туршилт тохируулгын зардлыг гүйцэтгэгч хариуцна.

		6. Баталгаат хугацаанд ашиглагчийг шаардлагатай сэлбэг хэрэгслээр тасралтгүй хангах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ.
10	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох.

ХЯНАСАН
ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ
АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Г.МӨНХ-ЭРДЭНЭ

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Г.ЭНХЦЭНГЭЛ

БОЛОВСРУУЛСАН
ТНААХ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Г.НЯМСҮРЭН